

**ДИПЛОМАТ, АЛБАН ПАСПОРТ БҮХИЙ ИРГЭД ХАРИЛЦАН
ВИЗГҮЙ ЗОРЧИХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ЧЕХ, СЛОВАКИЙН ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Чех, Словакийн Холбооны Бүгд Найрамдах Улсын Засгийн газар /цаашид “Хэлэлцэн тохирогч Талууд” гэж нэрлэнэ/ хоёр орон, ард түмний нөхөрсөг харилцааг хүлээн зөвшөөрч,

Дипломат, албан паспорт бүхий иргэдийг визээс харилцан чөлөөлөх нь Монгол Улс, Чех, Словакийн Холбооны Бүгд Найрамдах Улсын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ хэмээн,

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч нэг талын хүчин төгөлдөр дипломат, албан паспорт бүхий иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт түүний визгүйгээр чөлөөтэй орж, 3 сарын хугацаагаар байж болно.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч аль нэг талын нутаг дэвсгэр дэх Хэлэлцэн тохирогч нөгөө талын дипломат болон консулын төлөөлөгчдийн газрын бие бүрэлдэхүүний хүчин төгөлдөр дипломат, албан паспорт бүхий гишүүд, тэдний гэр бүл томилолтын хугацаандаа Хэлэлцэн тохирогч тухайн талын нутаг дэвсгэрт түүний визгүйгээр орж байж болно.

2. Хэлэлцэн тохирогч нэг талын нутаг дэвсгэрт байрладаг олон улсын байгууллагад суугаа Хэлэлцэн тохирогч нөгөө талын хүчин төгөлдөр дипломат, албан паспорт бүхий иргэд, тэдний гэр бүлд энэхүү зүйлийн нэгдүгээр заалтад олгосон эрх нэгэн адил хамаарна.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч нэг талын эрх бүхий байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө талын тааламжгүй гэж үзэж байгаа иргэдийг өөрийн нутаг дэвсгэрт оруулах буюу байлгах аас татгалзах эрхтэй.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч аль нэг тал нийгмийн хэв журам, аюулгүй байдал болон эрүүл мэндийг хамгаалах үүднээс энэхүү Хэлэлцээрийн заалтыг бүхэлд нь буюу хэсэгчлэн зогсоож болно.

2. Ийм арга хэмжээ авсан болон түүнийг цуцалснаа Хэлэлцэн тохирогч нэг тал Хэлэлцэн тохирогч нөгөө талдаа дипломат шугамаар нэн даруй мэдэгдэнэ.

ТАВДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч талууд дипломат, албан паспортуудын шинэ буюу шинэчилсэн загварыг дипломат шугамаар солилцоно. Чингэхдээ тэдгээрийг хэрэглэхээс доод тал нь 30 хоногийн өмнө нөгөө талд загварыг өгсөн байна.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийг тодорхой бус хугацаагаар байгуулав.

2. Энэхүү Хэлэлцээр гарын үсэг зурснаас хойш 30 дахь хоногтоо хүчин төгөлдөр болно. Энэ өдрөөс эхлэн БНМАУ-ын иргэд, БНСЧСУ-ын иргэд харилцан визгүй зорчих тухай БНМАУ-ын Засгийн газар, БНСЧСУ-ын Засгийн газар хооронд 1976 оны арван хоёрдугаар сарын 20-ны өдөр байгуулсан Хэлэлцээр, түүний нэмэлт Протокол хүчингүй болно.

3. Хэлэлцэн тохирогч талууд нот солилцох замаар энэхүү Хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

4. Хэлэлцэн тохирогч аль нэг тал Хэлэлцэн тохирогч нөгөө талд Хэлэлцээрийг цуцлах хүсэлтээ дипломат шугамаар бичгээр мэдэгдсэнээс хойш 3 сарын дараа энэхүү Хэлэлцээр хүчингүй болно.

Дээр дурдсаныг нотолж, тус тусын Засгийн газраас эрх олгосноор дор дурдсан хүмүүс энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурж, тамгаар баталгаажуулав.

Энэхүү Хэлэлцээрийг 1992 оны 6 дугаар сарын 26-нд Улаанбаатар хотноо монгол, чех хэлээр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх хувиуд адил хүчинтэй байна.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ӨМНӨӨС**

**ЧЕХ,СЛОВАКИЙН
ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС**

No. C.j 305606/2011-KKM

Бүгд Найрамдах Чех Улсын Гадаад хэргийн яам Прага дахь Монгол Улсын Элчин сайдын яаманд хүндэтгэл илэрхийлэн Дипломат, албан паспорт эзэмшигчид харилцан визгүй зорчих тухай Чех, Словакийн Холбооны Улсын болон Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн /1992 оны 6 дугаар сарын 26, Улаанбаатар/ 4 дүгээр заалтыг үндэслэн Чехийн тал визгүй зорчих харилцааг Монголын хүчин төгөлдөр Дипломат паспорт эзэмшигчдээр хязгаарлаж түүнийг 2011 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлэхээ мэдээлж байна.

Монголын албан паспорт эзэмшигчид 2011 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн Чехийн газар нутагт нэвтрэх, байх тохиолдолд виз авах шаардлагатай болж байна.

Монгол Улс зорчих баримт бичгүүдийг хуульчлаагүй ба Монголын байгууллагууд албан паспортыг өргөн хүрээг хамарсан иргэдэд олгодог бөгөөд тэдгээр паспорт нь биометрийн ялтасан хамгаалалтгүй байгаа нөхцөл байдал нь Чехийн талыг энэхүү алхам хийхэд хүргэсэн болно.

Чехийн Гадаад хэргийн яам энэ завшааныг ашиглан Прага дахь Монгол Улсын Элчин сайдын яаманд өөрийн гүн хүндэтгэлээ дахин илэрхийлж байна.

2011 оны 7 дугаар сарын 29-ний
өдөр, Прага хот

Монгол Улсын Элчин сайдын яаманд,
Прага хот